



**Оюу Толгой ХХК**

Оюу Толгой ХХК

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

## ГАРЧИГ

1. ОРШИЛ.....	4
1.1. Зорилго.....	4
1.2. Хэрэглээ.....	4
1.3. Эхлэх огноо.....	4
1.4. Эрх мэдэл ба удирдлага.....	5
1.5. Тогтмол хянан шалгах.....	5
2. ХАМРАХ ХҮРЭЭ.....	5
2.1. Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ.....	5
2.2. Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал.....	5
3. ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА.....	7
3.1. Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх гол үүрэг, хариуцлага ...	7
3.2. Төслийн стандарт.....	8
3.3. Удирдлагын хяналт.....	9
4. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ.....	18
4.1. Энэхүү Удирдлагын тогтолцоог хянах, шинэчлэ.....	18
5. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ.....	18
5.1. Хяналт шинжилгээнд тавигдах шаардлагын тойм.....	18
5.2. Ажлын гол үзүүлэлт.....	18
5.3. Хяналт шинжилгээний гол үйл ажиллагаа.....	19
6. СУРГАЛТ.....	19
6.1. Тойм.....	19
6.2. Сургалт зааварчилгаа.....	19
6.3. Тодорхой ажил үүргийн тусгай сургалт.....	19
6.4. Бусад сургалтанд хамрагдах шаардлага.....	19
7. АУДИТ БА ТАЙЛАН.....	20
7.1. Дотоод аудит.....	20

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

7.2. Гүйцэтгэгчийн аудит .....	20
7.3. Гадаад аудит .....	20
7.4. Гүйцэтгэлийн тайлагнал .....	20
8. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ .....	21

## ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1: Үндсэн үүрэг, хариуцлага бүхий албан тушаалтнууд .....	7
Хүснэгт 2: Хангамжийн болон гүйцэтгэгчийг удирдах гол үе шат, арга хэмжээ .....	10
Хүснэгт 3: Рио Тинтогийн Гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид тавих шаардлага, тэдгээрийг ОТ-д хэрэгжүүлж буй байдал .....	12
Хүснэгт 4: Ажлын гол үзүүлэлт – Гүйцэтгэгчийн удирдлага (ГУ) .....	18

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

## 1. ОРШИЛ

### 1.1. Зорилго

Гүйцэтгэгчийг удирдах энэхүү тогтолцоо дараах зорилготой. Үүнд:

- Гүйцэтгэгчдийг ЭМААБО-ы төлөвлөгөөний 7-р бүрэлдэхүүн хэсгийн дагуу үр дүнтэй удирдан зохицуулах зөвлөмж, үйл явцыг бэлтгэн өгөх;
- Гүйцэтгэгчдийг үр дүнтэй удирдан зохицуулахын тулд хийх шаардлагатай: а) Урьдчилсан шалгаруулалт б) Эх үүсвэрийг тодорхойлох в) Худалдан авах г) Гүйцэтгэгчтэй хамтран ажиллах д) Гэрээний удирдлага е) Менежер томилох зэрэг үйл ажиллагаа тус бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- Дээрх үйл ажиллагаа бүрийг хариуцах албан тушаалтан, тэдний хүлээх үүргийг тодорхойлох;
- Ажлын гол үзүүлэлт зэрэг хяналт шинжилгээ хийх, тайлагнах журмыг тодорхойлох;
- Шаардлагатай бол энэхүү Удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу холбогдолтой туслах материал, систем, ашиглалтын журам, бусад мэдээллийг тогтоох.

### 1.2. Хэрэглээ

Үйлчилгээг хүргэх, эсхүл ЭМААБО-д нөлөөлж болзошгүй зүйл худалдан авахад Гүйцэтгэгчийг ажиллуулах “Оюу толгой”-н бүх үйл ажиллагаанд энэ журмыг мөрдөнө. Тусад нь удирдаж, тус Удирдлагын тогтолцооны баримт бичиг(Хэсэг 2.1-ийг үзнэ үү)-т тусгаагүй байж болох ирээдүйн бүтээн байгуулалт, холбогдох барилгын ажил(аливаа Цахилгаан станц орно)-аас бусад ОТ-н бүх үйл ажиллагаанд энэхүү Удирдлагын тогтолцоонд заасан шаардлагыг мөрдөнө.

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоонд “Оюу толгой”-н хэрэгжүүлдэг урьдчилсан шалгаруулалт, эх үүсвэрийг тодорхойлох, худалдан авах, гэрээний удирдлага, Гүйцэтгэгчидтэй хамтран ажиллах болон томилогдсон менежерүүдтэй холбоотой үйл явц, гүйцэтгэгчдийн удирдлагын талаар тоймлон тусгаж өгдөг бөгөөд Бараа, үйлчилгээний гэрээний Ерөнхий нөхцөлд нарийвчлан заасан нөхцөлийг давж үйлчлэхгүй болно. Бараа, үйлчилгээний гэрээний Ерөнхий нөхцөл, шаардлага дахь Гүйцэтгэгчтэй хамтран ажиллах дүрэм журамд ямарваа өөрчлөлт оруулснаар гүйцэтгэгчдийн удирдлагын тус тогтолцоонд өөрчлөлт оруулахад хүрнэ.

### 1.3. Эхлэх огноо

Энэхүү Удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

**1.4. Эрх мэдэл ба удирдлага**

ОТ-н Гүйцэтгэх удирдлагын хороо энэхүү Удирдлагын тогтолцоог 2013 оны 9-р сарын 1-нд батлав.

**1.5. Тогтмол хянан шалгах**

Дэд бүтэц, үйлчилгээний хэлтсийн Ерөнхий менежер Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоог хэрэгжүүлэх, мөрдөх ажлыг хариуцна. ОТ-н Хангамж, дэд бүтцийн хөгжил хариуцсан Дэд ерөнхийлөгч нь Гүйцэтгэгчийг удирдах энэхүү тогтолцооны хариуцагч болно. Төслийн бүтэц, дүрэм журамд орсон өөрчлөлтийг тусгахаар илүү ойр ойрхон давтамжтайгаар хянан шинэчлэх шаардлагатай болоогүй л бол тус Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоог хоёр жил тутам хянаж, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт, шинээр мэдээлэл оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлно. Энэхүү Удирдлагын тогтолцоонд өөрчлөлт оруулах аливаа хүсэлтийг Өөрчлөлтийг удирдах дүрэм журамд заасны дагуу хянуулж, батлуулна.

**2. ХАМРАХ ХҮРЭЭ****2.1. Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ**

Гүйцэтгэгчийг удирдах энэхүү тогтолцоонд ОТ-н бүх үйл ажиллагааг хамрах бөгөөд ОТ нь гүйцэтгэгч, нийлүүлэгчдээрээ ОТ-н стандарт, бусад шаардлагыг хэрхэн мөрдүүлж хэрэгжүүлдэгийг тодорхойлно. Зураг төсөл-Хангамж-Барилгын ажлын менежментийн гэрээ (ЗТХБАМГ)-ний хяналт дор ОТ-н стандарт, бусад шаардлагыг биелүүлэхийг гүйцэтгэгч, нийлүүлэгчээс шаарддаг ЗТХБАМГ-ний хүрээнд тусад нь удирдах ирээдүйн аливаа бүтээн байгуулалт, холбогдох барилгын ажил (Цахилгаан станцыг оролцуулан)-аас бусад ОТ-н бүх үйл ажиллагаанд тус Удирдлагын тогтолцоонд заасан шаардлагыг мөрдөнө.

**2.2. Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал**

Гүйцэтгэгчийг удирдах энэхүү тогтолцоо нь ОТ-н үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зориулан боловсруулсан “Үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөө”, журам, стандартуудаас бүрдсэн баримт бичгүүдийн нэг хэсэг юм.

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2



ОТ-оос томилсон Менежер, Гүйцэтгэгчдэд зориулсан дэлгэрэнгүй шат дамжлага, шаардлагыг заасан дараах баримт бичгийг Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоонд хураангуйлан оруулсан болно. Үүнд:

- ОТ-н бараа үйлчилгээ худалдан авахгэрээний ерөнхий нөхцөл
- ОТ-н Худалдан авах ажиллагаанд баримтлах зарчим (PR-00);
- Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх журам (PR-02);
- Стратегийн ач холбогдол бүхий гадаадын нийлүүлэгчидтэй хамтран ажиллахад баримтлах журам (PR-05);
- Өмнөговийн Нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай бодлого (PR-06);
- Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай (PR-07);
- ОТ-н Худалдан авалт хариуцсан ажилтны ёс зүйн дүрэм (PR-08);
- ОТ-с томилогдсон менежерт зориулсан гүйцэтгэгчтэй хамран ажиллах гарын авлага(ОТ-07- GDL-9007-E);
- Гүйцэтгэгчийн хамтын ажиллагааг дэмжих чиг үүрэгтэй оролцогч талын гарын авлага (ОТ-07-GDL-9006);
- Газар хөндөх зөвшөөрөл авах журам (ОТ-10-E9-PRC-0003) (үүнийг ОТ гүйцэтгэдэг бөгөөд гүйцэтгэгчид гүйцэтгэдэггүй. Энэ нь гүйцэтгэгчийн үйл ажиллагааг удирдана).

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

### 3. ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

#### 3.1. Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх гол үүрэг, хариуцлага

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэхалбан тушаалтнуудыг доорх Хүснэгт 1-д тоймлон үзүүллээ.

#### Хүснэгт 1: Үндсэн үүрэг, хариуцлага бүхий албан тушаалтнууд

Хариуцах эзэн	Үүрэг, хариуцлага
<b>Дэд бүтэц, үйчилгээний Ерөнхий менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Гүйцэтгэгчийг удирдах энэхүү тогтолцооны хэрэгжилт, мөрдөлтийг ерөнхийд нь хариуцаж,</li> <li>• Гүйцэтгэгчдээр ОТ-н гэрээний шаардлагуудыг мөрдүүлэх.</li> <li>• Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоотой холбоотой бүх бодлого, зарчим, журмыг хэрэгжүүлэх боломж олгохуйц нөөц хэрэглэгдэхүүнээр хангуулах.</li> </ul>
<b>Томилогдсон менежерүүд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Шаардлагатай бол ЭМААБО- ны хэлтэстэй зөвлөлдөн АЦХ-ий маягтаар Ажлын цар хүрээг боловсруулах.</li> <li>• Ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулахад Хангамжийн хэлтэст туслах.</li> <li>• Гүйцэтгэгчийн ЭМААБО, Чанар, Төслийн гүйцэтгэл, Барилгын ажил, бусад Удирдлагын төлөвлөгөөг баталж, гэрээ, ОТ-н шаардлага, төсөв, хуваарийн дагуу гүйцэтгүүлэхээр гэрээт ажлыг удирдах.</li> <li>• Ажлын хамрах хүрээнд тодорхойлсон асуудлыг шийдвэрлэх хангалттай хэмжээний ур чадвар, туршлага Гүйцэтгэгчид байхгүй бол, шаардагдах ямар нэг нэмэлт хяналтыг тогтоох.</li> <li>• Гүйцэтгэгч зохих багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй болохыг бататгахаар нөөц бололцоогоор хангах (Сургалтын хэлтэс тээврийн хэрэгслийг шалгана).</li> <li>• ОТ-н стандарт, шаардлагыг хангаж ажиллахад нь Гүйцэтгэгчид зөвлөгөө өгөх.</li> <li>• Ажил эхлэхийн өмнөх бүх ажлыг хангалттай түвшинд гүйцэтгүүлэхээр ажил эхлэхийн өмнөх хурал зохион байгуулах.</li> <li>• Шаардлагатай чиг баримжааг олгох тусгай сургалтад ажилчдыг хамруулах нөөц бололцоогоор хангах.</li> <li>• Ажиллах зөвшөөрөлд хяналт тавих, батлах. Үүнд: Ажиллах зөвшөөрөл олгох системийг ажиллуулдаг буюу ашигладаг бүх ажилтан энэ талаар сурч дадлагажсан байх.</li> <li>• ЭМААБО-ны Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг хийлгэх зэргээр Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд ерөнхий хяналт тавих.</li> </ul>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

	<ul style="list-style-type: none"> <li>Гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн үнэлгээний хуудсыг тогтмол бөглөж байх.</li> <li>Ажлыг дуусгах үйл явцыг удирдан зохицуулж, Гэрээний гүйцэтгэлийн хүлээлцэх актыг бөглөх.</li> </ul>
<b>Хангамжийн удирдах ажилтан</b>	<ul style="list-style-type: none"> <li>Чанарын шаардлага хангах, эх үүсвэрийг тогтоох, худалдан авах болон гэрээний удирдлагын журам, үйл явцыг хэрэгжүүлэх.</li> </ul>
<b>Гэрээт байгууллагатай хамтран ажиллах багийн менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>Гүйцэтгэгчидтэй хамтран ажиллах үйл явцыг хэрэгжүүлэх үйл явцын хэрэгжилтийг хангах.</li> </ul>
<b>ЭМААБООН- ийн хэлтэс</b>	<ul style="list-style-type: none"> <li>ОТ-н ЭМААБО-ны шаардлагыг Гүйцэтгэгчдээр мөрдүүлэхэд ерөнхий хяналт тавих</li> <li>Ажлын хамрах хүрээг боловсруулахад шаардлагатай дэмжлэг үзүүлэх.</li> </ul>
<b>Гүйцэтгэгчид</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын талбарыг аюулгүй байлгаж, энэ стандарт хийгээд гэрээний бүх заалтыг мөрдөх.</li> <li>Гүйцэтгэгчидтэй хамтран ажиллахад шаардагдах ЭМААБО-ы удирдлагын төлөвлөгөө буюу үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэн тушаах.</li> <li>Ажил эхлүүлэхээс өмнө “Оюу толгой”-оос зохион байгуулдаг үндсэн мэдлэг олгох, ур чадвар эзэмшүүлэх сургалтыг дүүргэх.</li> <li>Ажил эхлүүлэхээс өмнө хэрэв шаардлагатай бол эрүүл мэндийн дүгнэлт (“Ажилд эрүүл мэндээр тохирох эсэх”) хийлгүүлэх.</li> <li>Бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр Гэрээнд шаардлагын дагуу хангах.</li> <li>Химийн бодисыг Оюу толгойн ажлын талбарт авчрахын өмнө тэдгээр бодисын жагсаалтыг ХХАЛМ-тэй нь хамт гарган өгөх.</li> <li>Ажил эхлэхийн өмнө тухайн ажилд хамааралтай сургалт хийх бөгөөд тус сургалтад ажлын өмнөх шалгах хуудасны талаар үзнэ.</li> <li>Гэрээний удирдлагын болон гүйцэтгэгчтэй хамтран ажиллах бүх үйл ажиллагааг Гэрээний удирдлага болон Гүйцэтгэгчидтэй хамтран ажиллах багуудаар гүйцэтгүүлнэ.</li> <li>Бүх осол зөрчил, гэмтэл бэртлийг даруй мэдэгдэнэ.</li> </ul>

### 3.2. Төслийн стандарт

Төслийн бүх үйл ажиллагаанд холбогдох стандартуудыг даган мөрдөнө (“Төслийн стандарт”). Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө бүрт төслийн стандартыг тодорхойлох бөгөөд хариуцсан менежер нь Ажлын хамрах хүрээг боловсруулах ажлын хүрээнд Төслийн холбогдох стандарт, холбогдох шаардлагыг тодорхойлно.

БОНУТ-ний тогтолцоо (ОТ-10-PLN-0003)-ны Хавсралт 2-т хуульзүйн болон бусад шаардлагыг дэлгэрэнгүй зааж, түүнд нь Төслийн стандартын үндсэн, холбогдох мэдээллийг тусгасан бий.



Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

### 3.3. Удирдлагын хяналт

ОТЭМААБО-ны Удирдлагын тогтолцооны 7-р элемент (Нийлүүлэгч, Гүйцэтгэгчийн удирдлага)–д Рио Тинто Бүлгийн харьяа бизнесийн байгууллагуудын заавал дагаж мөрдөх Рио Тинтогийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, чанарын удирдлагын тогтолцооны стандарттай нийцсэн, нийлүүлэгч, гүйцэтгэгчийг удирдах арга аргачлалыг тодорхойлдог.

ОТ-н хэрэгжүүлж буй Гэрээг удирдан зохицуулах болон гүйцэтгэгчтэй хамтран ажиллах үйл явцын гол үе шатуудыг доор харуулав. Үүнд:

- Гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх: Нийлүүлэгчдийг “Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх журам”-ын дагуу шалгаруулна.
- Үйлчилгээ, холбогдох бараа бүтээгдэхүүний эх үүсвэрийг тогтоох: Шинэ гэрээг “Оюу толгой”-н Хангамжийн хэлтсийн “Эх үүсвэрийг тогтоох гарын авлага”-ын дагуу байгуулна.
- Үйлчилгээг худалдан авах: Худалдан авах ажлыг “Оюу толгой”-н Хангамжийн хэлтсийн “Худалдан авах журмын гарын авлага”-ын дагуу эрхэлнэ.
- Гэрээг удирдан зохицуулах: Гэрээний удирдлагыг “Оюу толгой”-н Хангамжийн хэлтсийн “Гэрээний удирдлагын гарын авлага”-ын дагуу гүйцэтгэнэ.
- Гүйцэтгэгчдийг зохицуулах: Гүйцэтгэгчидтэй хамтран ажиллах үйл явцыг Оюу толгойн “Гүйцэтгэгчидтэй хамтран ажиллах гарын авлага”-д тусгаж, тус гарын авлагын дагуу гүйцэтгэх бөгөөд үүнд төслийн талбайд хүн хүчээ татах, ажлыг удирдан зохицуулах, хянан нягтлах, хаах үе шат орно.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-M	Хувилбар: 1.2

### Хүснэгт 2: Хангамжийн болон гүйцэтгэгчийг удирдах гол үе шат, арга хэмжээ

	Гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх	Эх үүсвэрийг тогтоох	Худалдан авах	Гэрээний удирдлага
<b>Арга хэмжээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Мэдээллийн үндсэн санд нийлүүлэгчийг бүртгэх</li> <li>• Нийлүүлэгчийн эрсдэлд өртөх байдлын тодорхойлох</li> <li>• Нийлүүлэгчдийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх</li> <li>• Зөвлөмж ба тайлан</li> <li>• Баримт бүртгэлийг Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын үнэлгээний удирдлагын системд хянана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төслийг эхлүүлэх</li> <li>• Тендер шалгаруулах</li> <li>• Үнийн тохиролцоо</li> <li>• Гэрээ байгуулах санал</li> <li>• Гэрээний нөхцөлийг боловсруулж харилцан зөвшөөрөх</li> <li>• Гэрээг байгуулах</li> <li>• Гэрээг хүлээлгэн өгч, ажил эхлүүлэх</li> <li>• Худалдан авах ажиллагааны үр дүнтэй байдлыг хянах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Худалдан авах хүсэлт</li> <li>• Нийлүүлэгчийн суурь судалгаа</li> <li>• Тендер шалгаруулах</li> <li>• Худалдан авах захиалгыг гүйцэтгэх</li> <li>• Гэрээ байгуулсаны дараах удирдлага/хурдавчлах ажил</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эх үүсвэрийг тогтоох багаас гэрээг хүлээлгэн өгөх</li> <li>• Гэрээний тоймыг тодорхойлох (Гэрээний удирдлагын төлөвлөгөө)</li> <li>• Гэрээний даатгалд нийцүүлэх</li> <li>• Гэрээний гүйцэтгэлд нийцүүлэх</li> <li>• Гэрээний хяналт үзлэг</li> <li>• Нэхэмжлэхийг бататгах</li> <li>• Гэрээг хаах</li> <li>• Нэхэмжлэлийн удирдлага</li> </ul>
<b>Үйл ажиллагаанд ашиглах хэрэглүүрүүд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх удирдлагын систем</li> <li>• Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх хэрэгсэл</li> <li>• “Оюу толгой”-н Хангамжийн хэлтсийн Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын үнэлгээний журам</li> <li>• PR02 Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын үнэлгээний бодлого</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ариба</li> <li>• Echo sign</li> <li>• Төлөөлүүлсэн санхүүгийн зөвшөөрөл (DFA)</li> <li>• Ажлын даалгавар, тендерийн санал авах урилга, цорын ганц эх үүсвэр</li> <li>• “Оюу толгой”-н Хангамжийн хэлтсийн “Эх үүсвэрийг тогтоох журмын гарын авлага”</li> <li>• Ар-Ти-Эй-ийн Төсөл хэрэгжүүлэх үндэслэл</li> <li>• Гэрээнд гарын үсэг зурж хүчин төгөлдөр болгох хүсэлт</li> <li>• ... илгээхийг хүсэх хэсэг</li> <li>• “Оюу толгой”-н цахим хуудас</li> <li>• ЭМААБО-ы үнэлгээ, орон нутаг, хууль дүрмийн хэрэгжилтийн эрсдэлийг хамруулсан эрсдэлийн үнэлгээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• РТБШ</li> <li>• “Оюу толгой”-н Хангамжийн “Худалдан авах журмын гарын авлага”</li> <li>• Төлөөлүүлсэн санхүүгийн зөвшөөрөл (DFA)</li> <li>• ... илгээхийг хүсэх хэсэг</li> <li>• “Оюу толгой”-н цахим хуудас</li> <li>• Цорын ганц эх үүсвэр</li> <li>• Рио Тинтогийн сургалтын удирдлагын систем</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэрээний удирдлага</li> <li>• Оюу толгой”-н Хангамжийн хэлтсийн Гэрээний удирдлагын журам</li> </ul>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

Гүйцэтгэгчидтэй хамтран ажиллах (Гүйцэтгэгчдийг зохицуулах)			
	<u>Эхлүүлэх</u>	<u>Ажлыг удирдан зохицуулах</u>	<u>Хянан үзэж, хаах</u>
Арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэшил, гэрээ хэрэгжүүлэх чадвар, тусгай зөвшөөрлийг нягтлах</li> <li>• Сургалтын шаардлагыг биелүүлсэн байдал</li> <li>• Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үзэж шалгах</li> <li>• Химийн бодисын зөвшөөрөл</li> <li>• Гүйцэтгэгчийн эрүүл мэндийн үзлэг</li> <li>• Аюул эрсдэлийн үнэлгээ</li> <li>• ЭМААБО-ы удирдлага/ Үйл ажиллагааны төлөвлөгөө</li> <li>• Ажил эхлэхийн өмнөх хурал хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн гол үзүүлэлт/Гүйцэтгэлийн онооны картыг үнэлэх хурал</li> <li>• Талбайн ахлах ажилтан, батлах/зөвшөөрөл олгох менежер</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төслийг дүгнэх сар тутмын болон эцсийн хурал</li> <li>• РТБШ-д Гүйцэтгэгчийн баримт мэдээллийг шинэчлэх (SAP-аас гарах)</li> <li>• Гүйцэтгэгчийн тоо баримтын талаар ОТ-ын МТ-ийн хэлтэст мэдэгдэх (Цахим шуудангийн хаяг)</li> </ul>
Үйл ажиллагааны хэрэглүүрүүд	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМААБО болон үйл ажиллагааны багц</li> <li>• ЭМААБО-ны удирдлагын төлөвлөгөөний заавар, шалгах хуудас</li> <li>• Сургалтын бүртгэл</li> <li>• Ажилтан, багаж, тоног төхөөрөмжийг бүртгэх загвар</li> <li>• Ажлын өмнөх хурлын шалгах хуудас</li> <li>• Химийн бодисын жагсаалт</li> <li>• Гэрээт байгууллагын хамтын ажиллагааны ном болон хариуцах менежер</li> <li>• ГБХА-ны багийн RACI хүснэгт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын стандарт журам</li> <li>• УХААН ба ААДШ</li> <li>• Ажиллах зөвшөөрөл олгох систем</li> <li>• Гүйцэтгэлийн онооны картны загвар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тойрох хуудас</li> <li>• Гүйцэтгэлийн эцсийн онооны карт</li> </ul>
Өөрчлөлтийн хэрэглүүрүүд	<ul style="list-style-type: none"> <li>• Танхимын сургалт</li> <li>• Ажлын өмнөх хурлын үеийн сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын байран дахь сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Танхимын сургалт</li> </ul>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-M	Хувилбар: 1.2

Доорх Хүснэгт 3-д ОТ ЭМААБО-ны Удирдлагын тогтолцооны 7 элементэд тавих шаардлагуудыг ОТ хэрхэн биелүүлж байгааг харуулав.

### Хүснэгт 3: Рио Тинтогийн Гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид тавих шаардлага, тэдгээрийг ОТ-д хэрэгжүүлж буй байдал

№	Заалт	Тавих шаардлага	Хэрэгжүүлэлт	Баталгаажуулах арга хэрэгсэл
ГУ01	7.1	<p>Төслийн стандартуудыг үл хэрэгжүүлэх, үл мөрдөх эрсдэлийн үнэлгээ зэрэг бараа материал, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээ, ажлын төлөвлөгөөт ханган нийлүүлэлттэй холбогдох эрсдэлийг тодорхойлж, үнэлэх арга барилтай байх шаардлагатай. Үүнд сонгон шалгаруулалтаас гарах дараа дараагийн нөлөөллийн дүн шинжилгээ орно.</p> <p><i>Санамж: Аль төрлийн эрсдэлийн үнэлгээг хийх шийдвэрийг хариуцсан менежер гаргана.</i></p>	<p>Ажлын цар хүрээг тодорхойлох маягт</p> <p>Гэрээний эрсдэлийн үнэлгээ</p> <p>Аюул осол буюу эрсдэлийн үнэлгээг хийнэ.</p>	<p>Санхүүгийн төлөөлүүлсэн баталгааны (DFA) дагуу батлагдсан Ажлын цар хүрээ, Гүйцэтгэгчид тулгарах эрсдэлийн үнэлгээг Санхүүгийн төлөөлүүлсэн баталгааны дагуу батална.</p> <p>Аюул/ эрсдэлийн үнэлгээ (шаардлагатай бол)</p>
ГУ02	7.2	<p>Техникийн тодорхойлолт, зураг төслийн шалгуур, Төслийн стандартуудад нийцсэн бараа материал, тоног төхөөрөмж ба/буюу ажил үйлчилгээг ханган нийлүүлэх нийлүүлэгчийн чадварыг үнэлэх арга барилтай байх шаардлагатай.</p> <p>Үнэлгээ, түүнтэй холбогдох аливаа үйл ажиллагааг баримтжуулсан байх ёстой.</p> <p>Нийлүүлэгчийн сонгон шалгаруулалт, үнэлгээ, дахин үнэлгээ, бүтээгдэхүүн(үүд) эсвэл материал(ууд)-аас татгалзах шалгуурыг тогтоосон дүрэм журмаар тус арга барилыг хэрэгжүүлнэ.</p>	<p>Тендерийн хураангуй</p> <p>Гэрээ байгуулах санал</p> <p>Төслийн стандартуудтай харьцуулж үнэлэх</p>	<p>Тендерийн хураангуй болон Гэрээ байгуулах саналыг Санхүүгийн төлөөлүүлсэн баталгаа (DFA) – ны дагуу батална.</p>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-M	Хувилбар: 1.2

ГУ03	7.3	<p>Эрсдэлийн үнэлгээний арга барилд тодорхойлсноор, худалдан авсан, эсвэл нийлүүлсэн бүх бараа материал, тоног төхөөрөмж, үйлчилгээ, ажил нь тэдгээрийн зорилтот хэрэглээ, үйл ажиллагаатай холбогдох ЭМААБО, орон нутаг, хууль дүрмийн хэрэгжилтийн эрсдэлийг хянахад шаардагдах техникийн тодорхойлолтыг хангасан байх шаардлагатай.</p> <p>Илүү хатуу чанд шаардлагыг мөрдөх, эсвэл тэдгээрийг ханган нийлүүлэлтийн гэрээнд өөр бусад байдлаар тодорхойлохгүй бол, ОТ төслийн стандартуудыг мөрдөнө. (Худалдан авах ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <i>Худалдан авах ажиллагааны зарчим: Бид хэрхэн худалдан авдаг</i> вэ-д тодорхойлсон болно.)</p> <p><i>Санамж: Газар хөндөх зөвшөөрөл авах журмыг ОТ-с томилсон менежер хэрэгжүүлэх бөгөөд гүйцэтгэгчийн ажлын хамрах хүрээг боловсруулахад ашиглах эрсдэлийн үнэлгээнд уг дүрэм журмын үр дүнг тусгадаг.</i></p>	Тендерийн үнэлгээ  Үнэлгээ хийсэн шалгуур  Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх	Тендерийн үнэлгээг хийсэн шалгуур  Гэрээ хэрэгжүүлэх чадварын үнэлгээний хөндлөнгийн шалгалтын тайлан, зөвлөмж
ГУ04	7.4	<p>Төслийн талбайд ашиглахаар батласан аюултай бараа материалын бүртгэлийг хөтлөх ёстой (бараа материалын системтэй холбоостой бол сайн). Шинэ бараа материалыг худалдан авах, ашиглахад хяналт тавих зорилгоор энэхүү бүртгэлийг бэлэн байлгаж, лавлагаа болгон, шинэчилж байх шаардлагатай.</p> <p>Гүйцэтгэгч, зочдын шинээр нэвтрүүлсэн бүх аюултай бараа материалыг энэхүү бүртгэлд нэмж, бүртгэлтэй харьцуулж үнэлж байх ёстой.</p>	ХАЛМ-ыг батлуулахаар ЭМААБО-ны хэлтэст хүргүүлэх	ChemAlert
ГУ05	7.5	<p>Бүх бараа материалын шинж чанарт үзүүлэх нөлөөлөл нь ЭМААБО-ны гүйцэтгэлд ноцтой эрсдэл учруулахуйц бол тэдгээрийн шинж чанарыг (боловсруулалтын шатанд гарах бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн, хаягдал зэрэг) зохих ёсоор ойлгож, баримтжуулан, үйл ажиллагааны журамд тусгах шаардлагатай.</p> <p>Дээрх бараа материал (бүтээгдэхүүн орно)-ыг хүргүүлэх, ашиглахаас өмнө хуульзүйн шаардлага хангасан ХАЛМ-ийг бэлэн болгох шаардлагатай</p>	ХАЛМ-ыг батлуулахаар ЭМААБО-ны хэлтэст хүргүүлэх	ChemAlert

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

ГУ06	7.6	<p>Гүйцэтгэгч нь бүх тоног төхөөрөмж, бараа материалыг Төслийн стандартуудын дагуу хүлээн авах, хадгалах, хүргүүлэх, тээвэрлэх эрсдэлийн үнэлгээ бүхий журмыг боловсруулсан байх үүрэгтэй.</p> <p>Санамж:</p> <p><i>(i) худалдан авах ажиллагааны хүрээнд эрсдэлийн үнэлгээг тохиолдол бүрт хийнэ. Худалдан авах ажиллагаанд ашиглах ЭМААБО-ны Удирдлагын төлөвлөгөөний зааварчилгаанд Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг оруулна.</i></p> <p><i>(ii) Гүйцэтгэгчид ЭМААБО-ны Удирдлагын төлөвлөгөө (Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө орно)-г боловсруулах ба Гүйцэтгэгчид төслийн талбай дээр ирэхээс өмнө үүнийг нь ОТ (ЭМААБО-ны Ахлах мэргэжилтэн, ОТ-с томилсон менежер) хянана</i></p>	<p>Гэрээ байгуулахын өмнө Гүйцэтгэгчийн ЭМААБО-ны төлөвлөгөөг цэгнэн үзэх.</p> <p>ЭМААБО-ны удирдлагын төлөвлөгөө буюу үйл ажиллагааны төлөвлөгөөг ажил эхлэхийн өмнө батлах.</p>	<p>Гэрээ байгуулахын өмнө дүгнэн цэгнэсэн Гүйцэтгэгчийн ЭМААБО-ны төлөвлөгөө.</p> <p>ЭМААБО-ны удирдлагын үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөө</p>
ГУ07	7.7	<p>Гүйцэтгэгч нь илүүдэл/ашигласан бараа материал, химийн бодис, аюултай хаягдал, тоног төхөөрөмжийг Төслийн стандартуудын дагуу, зөвшөөрлийн дагуу аюулгүй байдлаар зайлуулах үйл ажиллагааг хянах дүрэм журамтай байх ёстой. Гүйцэтгэгч нь ирээдүйд хүлээх аливаа хариуцлагыг бууруулахад шаардагдах арга хэмжээг тодорхойлсон байх ёстой.</p>	<p>Гүйцэтгэгчийн ЭМААБО-ны төлөвлөгөөг батлах</p> <p>Аюултай бараа материалын менежментийн төлөвлөгөө ОТ-10-E5-PLN-0001</p> <p>Эрдсийн бус хаягдлын менежментийн төлөвлөгөө ОТ-10-E7-PLN-0001</p>	<p>Бүртгэлийг хянах</p> <p>Гүйцэтгэгчийн ЭМААБО-ны төлөвлөгөө</p>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-M	Хувилбар: 1.2

ГУ08	7.8	<p>Гэрээт бүх ажил, үйлчилгээг <i>Гүйцэтгэгчийг удирдах шат дараалалд</i> тодорхойлсоноор төрөлжүүлж удирдах шаардлагатай.</p> <p>Гүйцэтгэгчийг удирдах арга барил нь дараах үе шатаас бүрдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>a) гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт</li> <li>b) гүйцэтгэгчийг бэлтгэх</li> <li>c) гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах</li> <li>d) зааварчилгаа ба сургалт</li> <li>e) гүйцэтгэгчийг удирдах</li> <li>f) үнэлгээний дараах үе шат</li> </ul> <p>Явуулж буй үйл ажиллагаа/удирдаж буй ажлын талбайд түр, эсвэл байнгын гэрээгээр ажиллах хувь хүмүүсийг үндсэн ажилтнуудын адилаар сургалт зааварчилгаанд хамруулж, удирдан зохион байгуулна.</p>	<p>ОТ-н худалдан авах ажиллагааны зарчим (Хавсралт В)</p> <p>Ажиллах хүчний менежментийн төлөвлөгөө ОТ-10-PLN-0005</p>	Бүртгэлийг хянах
ГУ09	7.9	<p>Бүх гэрээт ажил, үйлчилгээний гэрээний тухайд, Гүйцэтгэгчийн явуулах үйл ажиллагаатай холбогдох эрсдэлийн шинжилгээг, тэр дундаа Төслийн стандартуудыг үл хэрэгжүүлэх, үл мөрдөх байдлаас үүдэн гарах эрсдэлийн үнэлгээг тусгасан, харилцан тохиролцсон ажлын хамрах хүрээг оруулсан байна. Эрсдэлийн үнэлгээний шаардлагатай түвшинг Ажлын хамрах хүрээг боловсруулах явцад тодорхойлох боловч, үүнд АХХ тодорхойлогчид тусгасны дагуу ЭМААБО-ны аюул ослын тодорхойлолт, орон нутаг, хууль дүрмийн хэрэгжилтийн эрсдэлийг зайлшгүй тусгана. <i>(ГУ03 Газар хөндөх зөвшөөрөл авах журмыг үзнэ үү).</i></p>	<p>АХХ тодорхойлогчийг ашиглан Ажлын хамрах хүрээг боловсруулах.</p> <p>Аюул эрсдэлийн үнэлгээ хийнэ.</p>	Ажлын хамрах хүрээ болон аюул эрсдэлийн үнэлгээ (шаардлагатай бол)
ГУ10	7.10	<p>Гүйцэтгэгчид ЭМААБО-ны Удирдлагын тогтолцоог мөрдөх бөгөөд үүнд бүх Гүйцэтгэгчийн бүх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг аюулгүй ажиллагаатай байлгах, Рио Тинтогийн стандарт, Төслийн талбайн журмыг хангуулахаар шалгах, үнэлэх үйл явцыг тусгасан байдаг.</p>	<p>Хүн хүч, тоног төхөөрөмжөө төслийн талбайд татах үйл явцад багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хяналт шалгалт орно.</p>	Бүртгэлийн хяналт

**Санамж 1:** Бүх гүйцэтгэгчид ОТ ЭМААБО-ны Удирдлагын тогтолцооны дагуу ажиллана.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

### 3.3.1 Дараах хүснэгтэд гүйцэтгэгчийн ангилал бүрт хамааралтай мэдээлэл, шаардлагыг тусгав.

	CAT1	CAT2	CAT3
Шаардлага	Түр орлох ажилтан	ОТ-н явуулж буй үйл ажиллагаанаас тусдаа төсөл	Оюу толгойд үйлчилгээ үзүүлэх гэрээ
Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх удирдлагын системд (SQMS*) гүйцэтгэгчийг бүртгэх	X	X	X
Даатгалын нотолгоо	X	X	X
Ажлын цар хүрээн дэх эрсдэл буюу аюулыг тодорхойлох		X	X
Гэрээ байгуулахын өмнө ЭМААБО-ы удирдлагын төлөвлөгөө буюу эрсдэлийн үнэлгээг нь нягтлан үзэх.		X	X
Эх үүсвэр тодорхойлох багийн хийх ажил эхлүүлэх хурал	X	X	X
ЭМААБО-ы үйл ажиллагааны төлөвлөгөө		X	X
Ажил эхлэхийн өмнөх хурал		X	X
ЭМААБО-ы онооны картын тогтмол хурал			X
Сургалт, төслийн талбайн танилцуулга сургалт	X	X	X

\*Үл хамрагдах зүйлс: Маргаангүй нийлүүлэгчид (төрийн болоод хуулийн байгууллага, компани хооронд, гишүүнчлэлийн ба холбоонд өгсөн хандив, төлсөн төлбөр, татвар, зардал, нөхөн төлбөр), сонин, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөр, компанийн төлбөрийн картаар зоогийн газар хийсэн төлбөр.

**1-р ангиллын гүйцэтгэгчид:** Эрхэлж буй үйл ажиллагааны хүрээнд түр гэрээгээр ажиллаж компани, хувь хүн. “Оюу толгой”-н үндсэн ажилтны ажилладаг орон тоонд түр ажиллаж байж болно.

“Оюу толгой”-н бүтэц зохион байгуулалтад шууд ордог ажил үүрэг/албан тушаал. Ийм гэрээт ажилтнуудыг нэг бол түр ажилтнуудын биржээр дамжуулан ажилд авдаг, үгүй бол зөвлөх мэргэжилтнүүд байдаг. Тухайн үйлдвэр буюу хэлтэс уг ажлыг байрны хэрэгцээг гаргаж, ажлыг



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

шууд хянадаг/удирддаг тул Гүйцэтгэгч нийлүүлсэн хүн хүчээ/ажилтнаа хянаж удирдахгүй. Эдгээр ажилтнуудын ажлыг бүх талаас нь (ЭМААБО-ыг хамруулан) “Оюу толгой”-н үндсэн ажилтан мэт нэгэн адил удирдана. Эдгээр ажилтан Хүний нөөцийн хэлтэсээс бүтэц, зохион байгуулалтад орсон ажлын орон тоонд/албан тушаалд ажиллана.

**2-р ангиллын гүйцэтгэгчид:** “Оюу толгой”-н эрхэлж буй үйл ажиллагаанаас тусдаа орших, заасан газар хэрэгжүүлэх тусдаа төсөлд ажиллах компани буюу хувь хүн. Ийм гүйцэтгэгчид үйлдвэрлэлээс тусдаа, бие даасан байх бөгөөд өөрсдийн гэрээт ажлыг аюулгүй, “Оюу толгой”-н болон хууль хяналтын холбогдох шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх үүргийг “Оюу толгой”-н өмнө хүлээнэ.

ЭМААБО-ы шаардлагыг гэрээнд оруулж тодорхойлно (Гэрээг хариуцагч болон ЭМААБО-ы хэлтэстэй харилцан зөвшөөрсөний дараа)

**3-р ангиллын гүйцэтгэгчид:** Үйлдвэрлэлийн/Үйл ажиллагааны явцад Эхлэх, дуусах тодорхой огноотой тодорхой ажил эсхүл үйлчилгээг гэрээ гүйцэтгэх компани юмуу хувь хүн. Гэрээт ажилтнуудыг тухайн компани хяналт удирдлага дор ажиллуулах боловч ерөнхийдөө “Оюу толгой”-н ажилтнуудтай зэрэгцээ буюу ойр ажиллаж, “Оюу толгой”-н ажил эрхлэх зөвшөөрлийн журам, ЭМААБО-ы шаардлагыг удирдлага болгон өдөр тутам үйлчилгээг гүйцэтгэнэ.

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

#### **4. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ**

##### **4.1. Энэхүү Удирдлагын тогтолцоог хянах, шинэчлэ**

Үйл ажиллагаа, эсвэл байгаль орчны нөхцөл байдал шаардвал энэхүү Удирдлагын тогтолцоог хоёр жил тутамд болон түүнээс ойр давтамжтайгаар хянан тохиолдуулна.

#### **5. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

##### **5.1. Хяналт шинжилгээнд тавигдах шаардлагын тойм**

Төслийн стандартууд (4-р Хэсэг: Төслийн стандартууд-ыг үзнэ үү)-ын хэрэгжилтийг үнэлэхээр ашиглалтын үе шатанд хэрэгжүүлэх Хяналт шинжилгээний арга хэмжээг тус хэсэгт тодорхойлов. Хяналт шинжилгээгээр төслийн стандартуудыг үл хэрэгжүүлсэн байдал илэрвэл, уг зөрчлийг судлан шинжилэ, зохих засан залруулах арга хэмжээг тодорхойлно (Элемент 14 ОТ-н ЭМААБО-ны УТ-ны Үл тохирол, осол зөрчлийн үед авах хариу арга хэмжээ).

##### **5.2. Ажлын гол үзүүлэлт**

ОТ-д Гүйцэтгэгчийн удирдлагатай холбогдуулан гүйцэтгэлийг үнэлэхэд ашиглах Ажлын гол үзүүлэлт (АГҮ)-үүдийг доорх Хүснэгт4-д үзүүлэв.

#### **Хүснэгт 4: Ажлын гол үзүүлэлт – Гүйцэтгэгчийн удирдлага (ГУ)**

Дугаар	АГҮ	Зорилт	Хяналт шинжилгээний арга хэмжээ
ГУ-АГҮ 01	Гүйцэтгэгч зайлшгүй хүчин зүйлтэй нь шууд холбоотой ЭМААБО-ны осол зөрчлийн тоо*	Мэдээлсэн осол зөрчлийн тоог бууруулж, тасралтгүй сайжруулах	Гүйцэтгэгчийн жил бүр мэдээлсэн осол зөрчлийн тоо
ГУ-АГҮ 02	Гүйцэтгэгчтэй холбогдуулан орон нутгийн иргэдээс гаргасан санал гомдлын тоо	Мэдээлсэн санал гомдлын тоог бууруулж, тасралтгүй сайжруулах	Гүйцэтгэгчтэй холбогдуулан гаргасан санал гомдлын тоо (санал гомдлын журмыг удирдан зохицуулдаг БНХНА-тай холбоо харилцаатай байх
СМ-КР1-03	Аюултай болон аюул занал учруулах бүх бараа бүтээгдэхүүн, материал батлагдсан ХХАЛМ-тэй байх бөгөөд бүх гүйцэтгэгч энэ журмыг мөрдөнө.	“Оюу толгой”-д худалдан авч, ашиглах бүх материал, бараа бүтээгдэхүүнийг 7-р бүрдэл хэсгийн дагуу хийх.	

\*Осол зөрчил гэж дараахийн аль нэгийг болон түүнээс олон нөлөөлөлд хүргэх, эсвэл хүргэж болох нэг удаагийн тохиолдол, эсвэл байнгын/давтагддаг цуврал тохиолдлыг хэлнэ. Үүнд: ажлын байран дээрх бэртэл гэмтэл эсвэл өвчин зовлон, биет хөрөнгө (тухайлбал, үйлдвэр, тоног төхөөрөмж), байгаль орчин, үйлдвэрлэлийн үе шат, бараа бүтээгдэхүүн, болон нэр хүндийн хохирол, орон нутгийн иргэдэд төвөг чирэгдэл учруулах, хуульзүйн хариуцлага хүлээх үйл ажиллагаа явуулах, аюулгүй байдалд заналхийлэх орно. Нөлөөллийн төрөл бүрт учруулах бодит үр дагавар, боломжит хамгийн дээд үр дагавраар нь үнэлнэ.

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

### 5.3. Хяналт шинжилгээний гол үйл ажиллагаа

Гэрээний удирдлага ба гүйцэтгэгчидтэй хамтран ажиллах үйл явцын хүрээнд Гүйцэтгэгчид хяналт шинжилгээ хийх бөгөөд энэ нь дараахаас бүрдэнэ. Үүнд:

- Гүйцэтгэгчийн ЭМААБО-ны удирдлагын төлөвлөгөө, Бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд тавих ОТ-н Ерөнхий нөхцөл (Хавсралт А)-ийн дагуу хяналт шинжилгээг хийх;
- сар тутмын, эсвэл харилцан тохиролцсон бусад байдлаар Гүйцэтгэлийн үнэлгээний картыг бэлтгэх;
- Гэрээг нягтлан шалгах
- Даатгалын нөхцөлийг биелүүлэх
- ГГҮ-ийн шаардлагыг биелүүлэх
- Гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн хяналт шинжилгээг эрсдэлд суурилсан аргаар гэрээ тус бүрт заасан бий.

## 6. СУРГАЛТ

### 6.1. Тойм

Сургалт зааварчилгаа (ерөнхий мэдлэг олгох), тодорхой ажил үүргийн тусгай сургалтын хүрээнд шаардлагатай бүх сургалтыг явуулна.

### 6.2. Сургалт зааварчилгаа

ОТ дээр ажиллаж буй ОТ болон Гүйцэтгэгчийн бүх ажиллагсад ерөнхий сургалт зааварчилгаа, төслийн талбайн тусгай сургалт зааварчилгаа, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны мэдлэг олгох төрөл бүрийн сургалтанд хамрагдана.

### 6.3. Тодорхой ажил үүргийн тусгай сургалт

ОТ дээр ажиллаж буй бүх үндсэн ба гэрээт ажилтнууд ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны мэдээлэл солилцох хуралд оролцоно.

Хангамжийн хэлтсийн ажилтнууд гэрээний удирдлагын сургалт, болон хамрагдах шаардлагатай болж болох тухайн ажил үүргийн тусгай сургалтад хамрагдана.

Гүйцэтгэгчтэй хамтран ажиллах үйл явцын хүрээнд ажилтны ур чадварыг бататгах, ажилтны ур чадварыг удирдах зорилгоор ажилтны ур чадвар, сургалтын бүртгэлийг Гүйцэтгэгчээс авна.

### 6.4. Бусад сургалтанд хамрагдах шаардлага

Шаардлагатай үед, онцгой байдлын үед арга хэмжээ авах ур чадварыг эзэмшсэн байхыг Гүйцэтгэгчдээс шаардана.

Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

## 7. АУДИТ БА ТАЙЛАН

### 7.1. Дотоод аудит

Хэсэг 5.3-д зааснаар, удирдах ажилтнууд болон үйл ажиллагааны талбайн аюулгүй ажилагааны багууд нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны өргөн хүрээний өдөр тутмын, тогтмол хяналт шалгалтыг хийнэ.

Эдгээр хяналт шалгалтаар илэрсэн аливаа осол зөрчлийг Байгаль орчны Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний 14-р Хэсгийн дагуу мэдээлнэ.

Байгаль орчны Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний үндсэн баримт бичгийн 16-р Хэсгийн дагуу жил бүрийн дотоод аудитын хөтөлбөрөөр хууль дүрмийн хэрэгжилтэд хяналт тавина.

Энэхүү Удирдлагын төлөвлөгөөний хамгийн сүүлийн хувилбарыг ОТ-н бүх ажиллагсдад хүргэх үүднээс түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг ОТ Портал дээр тухай бүр байрлуулж байна.

### 7.2. Гүйцэтгэгчийн аудит

Хүн хүчний салбарын шаардлагыг мөрддөр нийлүүлэгчтэй ажиллах үүднээс "Оюу толгой" компанийн уурхайн цогцолбор дах үйлчилгээ гүйцэтгэгчдэд хууль дүрмийн хэрэгжилтийн хөндлөнгийн шалгалт тогтмол явуулах бөгөөд үүнийг Хангамжийн хэлтэс зохицуулна. Хяналт шалгалтаар ЭМААБО, хүний эрх ба хүний нөөц, бизнесийн ёс зүй, хууль зүй зэргийг авч үзэн "Оюу толгой"-н бодлого, улсын хууль журмын шаардлагыг мөрдөж буй байдлыг шалгана.

### 7.3. Гадаад аудит

Рио Тинтогийн байгууллагын аудит, баталгаажуулалтын хөтөлбөрөөс болон Төслийн зээлдүүлэгчдийн зүгээс энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол үнэлгээ хийнэ.

### 7.4. Гүйцэтгэлийн тайлагнал

Энэхүү төлөвлөгөөтэй харьцуулан хийсэн аудитын үр дүнг ОТ-н ахлах удирдлагад хүргүүлнэ.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-07-PLN-0001-М	Хувилбар: 1.2

### 8. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Файлын нэр	Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо ОТ-07-PLN-0001-М
Тодорхойлолт	Төслийн талбайд ЭМААБО-ны хууль дүрмийг мөрдүүлэхээр Гүйцэтгэгчийг удирдах журам
Эхийг зохиогч	Гэрээт байгууллагын харилцааны баг
Үүсгэсэн огноо	2013.09.01
Баталсан албан тушаалтан	Оюу Толгой ХХК-ийн Гүйцэтгэх хороо
Баталсан огноо	2013.09.01
Өөрчлөлтийг бүртгэх дугаар	##

Эрсдэлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Үнэлгээ хийсэн албан тушаалтан	Хянах хугацаа	Дараагийн хянах огноо
Дундаж	2013.09.01	Гүйцэтгэгчдийн удирдах төв удирдлагын Ахлах мэргэжилтэн Даваадоржийн Энхтуул	2 жил тутам	2017.06.01

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварласан тэмдэглэл
1.0	2013.09.01	Гэрээт байгууллагын харилцааны баг	Хангамж, дэд бүтцийн хөгжлийн Дэд ерөнхийлөгч Айвен Велла	Баталсан.
1.1	2013.11.23	Л.Мөнхцацрал	Хангамж, дэд бүтцийн хөгжлийн Дэд ерөнхийлөгч Айвен Велла	Лавлах баримт бичгийн дугаарыг засч, баримт бичгийн хяналт хийсэн.
1.2	2015.05.20	ЭМААБОАБОН, Хангамж, Гүйцэтгэгчидтэй хамтран ажиллах баг	Дэд бүтэц, үйлчилгээний хэлтсийн Ерөнхий менежер Эндрю Миллер	Тогтсон хугацаанд хянах Өөрчлөлт хийсэн тухай тэмдэглэл 2015-014